

Бурханд Итгэх Итгэл Хөвгүүдэд Зориулсан



*“Цорын ганц Үнэн Бурхан таныг
болон Таны илгээсэн Есүс Христийг
мэдэх нь мөнхийн амь мөн.”*

Иохан 17:3

Миний нэрийг _____ гэдэг.



БИ БУРХАНЫ ХҮҮХЭД

*Би Тэнгэрлэг Эцэг надад хайртай гэдгийг мэднэ,
би Түүнд хайртай.*

*Би Тэнгэрлэг Эцэгтээ хандан хэзээ ч,
хаана ч залбирч чадна.*

*Би Есүс Христийг дурсан санаж,
даган дуурайхыг хичээж байна.*

Хайрт Залуу Найз минь,

Чи бол Бурханы Хүүхэд мөн. Тэр бол чиний Тэнгэрлэг Эцэг. Тэр чамд хайртай бөгөөд чиний төлөө санаа тавьдаг. Тэрээр чамайг Түүнд итгэлтэй байж, Түүнд хандан байнга— хэзээ ч, хаана ч залбирахыг хүсдэг.

Тэр чамайг баптисм хүртэхдээ хийсэн гэрээгээ дагана, мөн Есүс Христийн сургаал болон жишээг дагана гэж найддаг. Тэрээр чамайг удирдан залах Ариун Сүнсний бэлгийг, чамайг хайрлаж, чамд зааж сургах гэр бүлийг, мөн чамд туслах Хүүхдийн Хэсгийн удирдагчдыг болон багш нарыг өгсөн билээ.

Одоо чи Аароны Санваар хүртэхээр бэлтгэж байна. Эдгээр жилүүдийг санваарын тухай сурахад болон үүнийг хүртэхэд бэлэн бөгөөд зохистой байхын тулд ашигла.

Бид чамайг сайн мэдээг сурч, үүний дагуу амьдран, бусдад үйлчилж, мөн сурч, олон сайн үйлс хий гэж Тэнгэрлэг Эцэгийн чамд өгсөн авъяасыг ашиглахыг уриалж байна. Бурханд Итгэх Итгэл Шагналыг авах нь чиний болохыг хүсдэг тэр хүн болоход чинь мөн чамайг болж чадна гэсэн Тэнгэрлэг Эцэгийн мэддэг тэр хүн болоход тусална.

Бид чамд хайртай бөгөөд чиний төлөө залбирдаг.

Тэргүүн Зөвлөл

МИНИЙ БАПТИСМЫН ГЭРЭЭ

Би баптисм хүртэхдээ Есүс Христийн нэрийг өөртөө хүлээн авч, Түүнд үйлчилж, дуулгавартай байна гэж гэрээ хийсэн.

Тэнгэрлэг Эцэг надад Ариун Сүнсийг өгсөн. Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан би наманчлахдаа нүглүүдээсээ өршөөгдөж чадна.

Хэрэв би баптисмын гэрээгээ дагавал Түүнтэй хамт амьдрахаар эргэн очиж чадна.



Би ариун ёслолоос хүртэхдээ Есүс Христийн нэрийг
өөр дээрээ хүлээн авч, Түүнийг үргэлж дурсан санаж,
Түүний зарлигуудыг дуулгавартай
дагана гэсэн гэрээгээ шинэчилдэг. Би үүнийг хийвэл
Ариун Сүнс намайг удирдаж байгааг мэдэрч чадна.

(Мозая 18:8–10 ба С ба Г 20:37-г үз.)



БУРХАНД ИТГЭХ ИТГЭЛ ШАГНАЛЫН БОЛЗЛУУД

Чи найман нас хүрэхдээ Бурханд Итгэх Итгэл Шагнал хүлээн авахаар ажиллаж эхэлж болно. Шагналыг авахын тулд чи арван хоёр нас хүрэхээсээ өмнө энэ удирдамжинд байгаа болзлуудыг биелүүлнэ. Чиний эцэг эх болон Хүүхдийн Хэсгийн удирдагчид үйл ажиллагаанд чинь тусалж болно.

Үндсэн Болзлууд

Бурханд Итгэх Итгэлийн чухал хэсэг нь баптисмынхаа гэрээг даган, сүнслэг байдлаараа хүчтэй байх явдал юм. Итгэлээ хөгжүүлж, уруу татлагаас зайлсхийхэд чамд туслах дараах зүйлсийг хийгээрэй:

- Тэнгэрлэг Эцэгт хандан өдөр бүр залбирах.
- Судраас тогтмол унших.
- Зарлигуудыг даган, “Сайн Мэдээний Миний Жишиг”-ээр амьдрах (арын хуудсыг үз).
- Эцэг эхээ хүндэтгэж, гэрийнхэнтэйгээ найрсаг байх.
- Аравны нэгээ төлж, аравны нэгийн хэлэлцүүлэгт оролцох.
- Ариун ёслолын цуглаан болон Хүүхдийн Хэсгийн цуглаанд оролцох.

Бусад Болзлууд

Дараах үйл ажиллагааг хийх нь чиний мэдлэгт болон сайн мэдээний талаарх гэрчлэлийн чинь өсөлтөнд тустай:

- Гэрчлэлээ бич.
- Итгэлийн Тунхагийг цээжлээд, тэдгээр нь ямар утгатайг тайлбарла.
- Удирдамжинд байгаа үйл ажиллагаануудыг гүйцээ:
 - Сайн Мэдээг Сурч, Үүний Дагуу Амьдрах нь (6 -р хуудас)
 - Бусдад Үйлчлэх нь (8 -р хуудас)
 - Авъяасаа Хөгжүүлэх нь (10 -р хуудас)
 - Санваарт Бэлтгэх нь (12 -р хуудас)
- Бишоп эсвэл салбарын ерөнхийлөгчтэй ярилцлаганд орох.

Бурханд Итгэх Итгэл Шагналыг авах үйл ажиллагаануудад зориулсан зарим санаануудыг энэ удирдамжинд бичсэн байгаа. Эцэг эхийн эсвэл Хүүхдийн Хэсгийн удирдагчийнхаа тусламжтайгаар чи бас өөр бусад үйл ажиллагааг төлөвлөн хийж болно. 20 -р хуудсан дахь хүснэгтийг өөрийнхөө хөгжлийг мэдэхийн тулд ашигла.



САЙН МЭДЭЭГ СУРЧ, ҮҮНИЙ ДАГУУ АМЬДРАХ НЬ


*“Өөрийн залууд мэргэн ухааныг суралц; тийм ээ,
өөрийн залууд Бурханы зарлигуудыг дагаж сурагтун.”*

Алма 37:35

Дараах үйл ажиллагаануудын жил бүр дор хаяж хоёрыг нь гүйцэтгэ:

- Ариун ёслолоос хүртэх нь баптисмынхаа гэрээг шинэчлэхэд чамд хэрхэн тусалдгийг тайлбарла. Гэр бүлийн үдэш дээрээ итгэлтэй байхын тулд бидний хийж болох зүйлсийн талаар бусдад заа.
- Иосеф Смитийн Анхны Үзэгдэл гэсэн хичээлийг гэр бүлийн үдэш дээрээ заа (Иосеф Смит—Түүх 1:1–20-ийг үз). Тэнгэрлэг Эцэг бидний чин сэтгэлийн залбиралд хэрхэн хариулдаг талаар ярилц.
- Ариун Сүнсний тухай эдгээр шүлгүүдийг судартаа тэмдэглэ: Иохан 14:16–17, 2 Нифай 32:5 ба Моронай 10:5. Ариун Сүнс чамд тусалдаг арга замуудын талаар ярилц.
- Сүүлчийн ерөнхий чуулган дээр Бошиглогчийн хэлсэн үгийг унш. Бошиглогчийг дагахын тулд чи юу хийж чадахаа шийдэж, үүнийгээ хий.
- Гэр бүлийн үдэш эсвэл Хүүхдийн Хэсгийн Цуглаан дээр нээлтийн болон хаалтын залбирал хий. Залбирал нь биднийг хэрхэн хамгаалж мөн Тэнгэрлэг Эцэгтэй болон Аврагчтай ойрхон байхад бидэнд тусалдаг талаар сэтгэгдлээ хуваалц.
- Есүс Христэд итгэх итгэлийн талаар заадаг түүхийг Мормоны Номноос ярь. Аврагчийн талаарх гэрчлэлээ хуваалц.

- С ба Г 89-ийг унш. Бид Мэргэн Ухааны Үгийн дагуу итгэлтэйгээр амьдрахад Тэнгэрлэг Эцэг биднийг хэрхэн адисладаг талаар ярилц. Мэргэн Ухааны Үгийг бусдад заах үйл ажиллагааг төлөвлөхөд болон хөтлөн явуулахад тусал.
- Өөрийн болон эцэг эхийнхээ мөн өвөө эмээгийнхээ нэртэй удмын бичгийг бэлтгэ. Гэр бүлдээ зориулж гэр бүлийн бичээс бэлтгэ, мөн гэр бүлийн түүхээ хуваалц. Ариун Сүмийн ажлыг гүйцэтгэх нь гэр бүлийг хэрхэн адисладгийг ярилц.
- “Зөвийг Сонго” (*Сүмийн Дуулал* х.239)-ыг дуулж сур. Сонголт гэж юу болох мөн сонголтондоо хариулцлага хүлээх гэдэг нь ямар утгатайг тайлбарла. Зөв сонголт хийх нь илүү их итгэлийг хөгжүүлэхэд чамд хэрхэн тусалдаг талаар ярилц.
- Сайн мэдээг сурч, үүний дагуу амьдрахад чамд туслах үйл ажиллагаагаа төлөвлөөд гүйцэтгэ (үйл ажиллагааг дор бич).



БУСДАД ҮЙЛЧЛЭХ НЬ

“Мөн болгоогтун, би та нарт эдгээр зүйлүүдийг та нар цэцэн ухааныг сурч болохын тул хэлнэ; та нар бусдадаа үйлчилж байх үед та нар зөвхөн өөрсдийн Бурханд үйлчилж байгаа гэдгээ мэдэж болохын тул буюу.”

Мозая 2:17

Дараах үйл ажиллагаануудын жил бүр дор хаяж хоёрыг нь гүйцэтгэ:

- Сайн санаат Самари хүний тухай сургаалт зүйрлэлийг уншаад ярилц (Лук 10:30–37-г үз). Гэр бүлийн гишүүн эсвэл хөршдөө туслах үйлчлэх ажлыг төлөвлөөд гүйцэтгэ. Ажлаа дуусгасны дараа энэ нь чиний итгэлийг хэрхэн өсгөснийг ярилц.



- Багшдаа, эцэг эхдээ эсвэл эмээ, өвөөдөө тэдэнд юунд нь талархдагаа, мөн юуг нь хүндэтгэдгээ бичсэн захиа бич.
 - Хүнд байдаг чамд таалагддаг зан чанаруудыг жагсааж бич. Өөртөө хөгжүүлэх нэг зан чанарыг сонго. Хүндэтгэл болон эелдэг ааш үзүүлэх нь чамайг, чиний гэр бүлийг мөн бусдыг хэрхэн бэхжүүлдгийг ярилц.
 - Тэжээллэг хоол хийхээр төлөвлөж, бэлтгээд, хий.
 - Сурсан эсвэл өөрөө зохиосон дуу буюу тоглоомоор жаахан хүүхдүүдийг хөгжөө. Жаахан хүүхдийг хэрхэн асарч, хамгаалахыг мэддэг гэдгээ харуул.
 - Зөв боловсон хүмүүжилтэй байхыг сур.
 - Оройн хоол, явган аялал, ууланд гарах, өдрийн зугаалга эсвэл үйлчлэлийн ажил гэх мэтийн эцэг эх, хүүхдийн үйл ажиллагааг төлөвлөөд, хий.
 - Итгэлийн арван хоёр дахь тунхгийг унш. Сайн иргэн байх гэдэг нь ямар утгатайг мөн чиний үйлдэл хэрхэн бусдад нөлөөлөх тухай ярилц.
 - Хүүхдийн Хэсгийн удирдагчиддаа дараагийн улирлын үйл ажиллагааг төлөвлөн явуулахад нь тусал.
 - Бусдад үйлчлэх өөрийн үйл ажиллагааг төлөвлөөд гүйцэтгэ. (үйл ажиллагааг дор бич).
-
-

АВЪЯАСАА ХӨГЖҮҮЛЭХ НЬ

*“Учир нь бүгдэд бэлэг бүхэн өгөгддөггүй;
учир нь олон бэлэг байдаг, мөн хүн болгонд
Бурханы Сүнсээр бэлэг өгөгддөг болой.”*

Сургаал ба Гэрээ 46:11

Дараах үйл ажиллагаануудын жил бүр дор хаяж хоёрыг нь гүйцэтгэ:

- Төсөв зохиож, мөнгөө хэрхэн хэмнэхийг сур. Аравны нэгээ итгэлтэйгээр төлөх нь яагаад чухал болох мөн ингэснээр Тэнгэрлэг Эцэг биднийг хэрхэн адисладгийг ярилц (3 Нифай 24:10–11-ийг үз). Аравны нэгээ төлж, номлолд зориулж мөнгөө хадгалж эхэл.
- *Хүүхдийн Дууны Номноос* дуу дуулж, тоглож эсвэл удирдаж сур. Гэр бүлийн үдэш эсвэл Хүүхдийн Хэсэгтээ тэр дуугаа заа эсвэл хуваалц. Авъяасаа хөгжүүлэх нь Тэнгэрлэг Эцэгт болон бусдад үйлчлэхэд өөрсдийгөө бэлтгэхэд бидэнд хэрхэн тусалдгийг ярилц.
- Сайн мэдээний зарчмыг заасан эсвэл Тэнгэрлэг Эцэгийн бүтээлийн тухай шүлэг, түүх эсвэл богинохон жүжиг бич.
- Модоор, төмрөөр, даавуугаар болон өөр материалуудаар юм хий, эсвэл зур, буд, эсвэл сийлбэр хий. Бусдад харуулахын тулд дууссан бүтээлээ дэлгэн тавь.
- Уран зургийн музей болон концерт, жүжиг үз эсвэл бусад соёлын үйл ажиллагаанд оролц. Үзсэн зүйлээ гэрийнхэнтэйгээ эсвэл үйл ажиллагааны өдрийн хэсгийнхэндээ хуваалц.



- С ба Г 88:118-ыг унш. “Бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэгтүн” гэдэг нь ямар утгатайг ярилц. Сайн номыг хэрхэн сонгож уншихыг сурах эсвэл өдөр болгон хичээлдээ бэлтгэх гэх мэтийн зүйлсийг хийснээр хувийн сургалтаа сайжруул.
- Гэртээ туслахын тулд хийж чадах таван зүйлийг жагсааж бич. Эцэг эхээ дуулгавартай дагаж, хүндэтгэх мөн ажил хийж сурахын чухлыг ярилц.
- Спорт болон тоглоом тоглож сурах зэргээр өөртөө зориулан биеийн тамирын хөтөлбөр зохио. Сард нэг удаа хөтөлбөрөө хий.
- Эрүүл хүнс, эрүүл бие болон даруухан хувцаслах зэргээр цэвэр цэмцгэр байх талаар сур.
- Авъяасаа хөгжүүлэхэд туслах үйл ажиллагааг төлөвлөөд гүйцэтгэ (үйл ажиллагааг доор бич).

САНВААРТ БЭЛТГЭХ НЬ

*“Аароны Санваар . . . нь дээд буюу Мелкизедек
Санваарын хавсралт байж, мөн гаднах ёслолуудыг
гүйцэтгэх хүчтэй байдаг.”*

Сургаал ба Гэрээ 107:13–14

11 настай байхдаа дараах үйл ажиллагаануудыг гүйцэтгэ.
Эдгээр нь чамд Аароны Санваар хүртэхэд болон шударга
залуу эрэгтэй болоход тусална.

- Аароны Санваарын сэргэлтийн талаар суралц (С ба Г 13, 107:20 ба Иосеф Смит—Түүх 1:68–73-ыг үз).
- С ба Г 20:57–60-ыг мөн Аароны Санваартан: *Бурханы Өмнө Хүлээсэн Үүргээ Биелүүлэх нь [Дикон]*, хуудас 7 -с унш. Эцэг эх болон удирдагчтайгаа Аароны Санваарын зорилго болон Бурханы өмнө хүлээсэн чиний үүрэг ямар утгатайн талаар ярилц.
- Диконы чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлтэй диконы чуулгын үүргийн талаар ярилц. Өдрийн тэмдэглэл дээрээ диконы чуулгын гишүүний хувьд чи хэрхэн Их Эзэнд үйлчилж болохыгоо бич.
- С ба Г 88:77–80, 118 ба С ба Г 130:19-ийг унш. Эцэг эхтэйгээ эсвэл Хүүхдийн Хэсгийн удирдагчтайгаа сайн боловсрол хичнээн чухлыг мөн энэ нь чамайг санваартны хувьд хэрхэн гэрт чинь, гэр бүлд чинь болон Сүмд бэхжүүлж чадахыг ярилц.
- “Гэр Бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг унш. Гэр бүлээ бэхжүүлэхэд болон аз жаргалтай гэр бий

болгоход тустай чиний хийж чадах зүйлүүдийг жагсааж бич. Үүнийгээ эцэг эх болон Хүүхдийн Хэсгийн удирдагчдаа үзүүл.



ИТГЭЛИЙН ТУНХАГ

ЕСҮС ХРИСТИЙН ХОЖМЫН ҮЕИЙН ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

1. Бид Бурхан, Мөнхийн Эцэг, Түүний Хүү Есүс Христ болон Ариун Сүнсэнд итгэдэг.
2. Хүмүүс Адамын гэмийн төлөө бус өөрсдийн нүглийн төлөө шийтгэгдэнэ гэдэгт бид итгэдэг.
3. Сайн Мэдээний хууль, ёслолуудыг дуулгавартай дагавал Христийн Цагаатгалаар бүх хүн төрөлхтөн аврагдах боломжтой гэдэгт бид итгэдэг.
4. Бид Сайн Мэдээний анхны зарчмууд болон ёслолууд нь: нэгдүгээрт, Их Эзэн Есүс Христэд итгэх итгэл; хоёрдугаарт, Наманчлал; гуравдугаарт, Нүглээс ангижрахын тулд усанд умбуулан хийгдэх баптисм; дөрөвдүгээрт, Толгой дээр гар тавиулан хүртэх Ариун Сүнсний Бэлэг гэдэгт итгэдэг.
5. Аливаа хүн Сайн Мэдээг номлож ёслолуудыг удирдан гүйцэтгэхийн тулд Бурханаар, бошигоор, эрх мэдэлтнээр толгой дээр гар тавиулан дуудагдсан байх ёстой гэдэгт бид итгэдэг.
6. Бид дагалдагч, бошиглогч, пастор, багш, сургаал номлогчид болон бусад хэмээсэн Анхны Сүмд байсан ижил зохион байгуулалтад итгэдэг.
7. Бид хэл эзэмших, бошиглох, илчлэх, үзэгдэл үзэх, эдгээх, хэлмэрчлэх болон бусад бэлгүүдэд итгэдэг.
8. Библи нь зөв орчуулагдсан аваас Бурханы үг гэдэгт бид итгэдэг; түүнчлэн Мормоны Ном нь Бурханы үг болоход бид итгэдэг.
9. Бид Бурханы илчилсэн бүхэнд, Түүний одоо илчилсээр буй бүхэнд итгэдэг бөгөөд Бурханы Хаант Улсын талаар олон агуу чухал зүйлийг илчлэх болно гэдэгт итгэдэг.
10. Бид Израилийн жинхэнэ ёсоор нэгдэх цугларалт, Арван Омгийн дахин сэргэлтэд итгэдэг. Сион (Шинэ Ерусалим) Америк тивд буй болж, Христ өөрийн биеэр эх дэлхийг эзэгнэн, газар дэлхий шинэчлэгдэн диваажингийн алдар хүндийг хүлээн авах болно гэдэгт итгэдэг.
11. Бид өөрсдийн зүрх сэтгэлийн хүсэл зоригоор Бүхнийг Чадагч Бурханыг шүтэх эрхтэй бөгөөд бүх хүмүүс хаана ч, яаж ч, юуг ч шүтэн бишрэх эрхтэй гэдгийг хүлээн зөвшөөрч тунхагладаг.
12. Бид хаан, ерөнхийлөгч, удирдагч, албан хаагчдад захирагдан, хууль цаазыг дуулгавартай дагаж, хүндэтгэн дээдэлж, мөрдөх ёстой гэдэгт итгэдэг.
13. Бид шударга, итгэлтэй, цэвэр ариун, сайн санаатай, ач буянтай байж хүн болгоны төлөө сайн үйл бүтээх явдалд итгэдэг. Чухамдаа бид “Бид бүх зүйлд итгэж, бүгдэд найддаг, бид олон зүйлийг тэвчээртэй даван туулсаар байгаа бөгөөд бүхнийг давах чадвартай хэмээн найддаг. Хэрэв ямар нэгэн ач буянтай, сэтгэл татам, сайн үүдэлтэй, бахархуштай зүйл байх аваас бид түүнд тэмүүлдэг” хэмээсэн Паулын сануулгыг дагадаг гэж хэлж болно.

ИОСЕФ СМИТ

ЭЦЭГ ЭХ БОЛОН УДИРДАГЧДАД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ

Эцэг эхчүүд хүүхдүүддээ сайн мэдээг суралцах болон үүний дагуу амьдрахад нь туслах үүрэгтэй. Хүүхдийн Хэсгийн удирдагчид болон багш нар эцэг эхэд энэ чухал үүрэгт нь туслан дэмждэг. Энэ Бурханд Итгэх Итгэл удирдамж нь охид хөвгүүдэд Бурханы хүүхдүүдийн хувьд өөрсдийн чадамжиндаа хүрэхэд нь туслах эх сурвалж болдог.

ЗОРИЛГО

Бурханд Итгэх Итгэл удирдамжуудын зорилго нь 8–11 насны охид хөвгүүдэд сайн мэдээний зарчмаар амьдрахад, гэрчлэлээ хөгжүүлэхэд, найз нөхөдтэй болоход, Аароны Санваар хүртэхэд бэлтгэхэд мөн шударга залуу эмэгтэй болоход нь туслах явдал юм. Удирдамжинд байгаа болзлуудыг биелүүлсэн хүүхдүүд Бурханд Итгэх Итгэл Шагналыг хүлээн авна.

ХӨТӨЛБӨР ЯАЖ ЯВАГДАХ ВЭ

Хүүхдүүд залбирах, судрууд унших болон “Сайн Мэдээний Миний Жишгүүд”-ийн (арын хуудсанд үз) дагуу амьдрах гэх мэтчилэн сайн мэдээний дадал зуршлыг хөгжүүлэхэд тэдэнд туслах үйл ажиллагаанд оролцдог. Мөн түүнчлэн тэд дараах зүйлүүдийн дагуу олон үйл ажиллагаанд оролцдог: (1) сайн мэдээг сурч, үүний дагуу амьдрах, (2) бусдад үйлчлэх, (3) авъяасаа хөгжүүлэх болон (4) санваар хүртэхэд буюу Залуу Эмэгтэйчүүдэд орох бэлтгэх.

Энэ хөтөлбөрт зориулсан үйл ажиллагаанууд нь хоёр удирдамжинд багтсан байгаа: *Хөвгүүдэд Зориулсан Бурханд Итгэх Итгэл ба Охидод Зориулсан Бурханд Итгэх Итгэл*. Хүүхдүүд үйл ажиллагаануудаа гэртээ, гэр бүлийнхэнтэйгээ, эсвэл Хүүхдийн Хэсгийн үйл ажиллагааны өдрөө хийж болно (18 -р хуудсыг үз).

ХҮҮХДИЙН ХЭСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨДРҮҮД

Хүүхдийн Хэсгийн үйл ажиллагааны өдрүүд нь 8–11 насны охид хөвгүүдэд Бурханд Итгэх Итгэл хөтөлбөрийн үйл ажиллагааг хийх боломжоор хангахад зориулагдсан юм. Үйл ажиллагааны

өдрүүд нь ихэвчлэн сард хоёр удаа гэртээ эсвэл цуглааны байранд явагддаг. Орон нутгийн төсвөөс Хүүхдийн Хэсгийн үйл ажиллагааны зардлыг гаргах ёстой. Үйл ажиллагааны өдрүүдийг залбирлаар нээж мөн хаах ёстой. Орон нутгийн хэрэгцээ болон шаардлагаас хамаарч үйл ажиллагааны өдрүүд Ням гарагаас бусад өдрүүдэд Сүмийн бусад үйл ажиллагаатай зэрэгцэн явагдаж болно.

Хааяа, удирдагчид Хүүхдийн Хэсгийн бяцхан хүүхдүүдийг 8–11 насны хүүхдүүдтэй хамт үйл ажиллагааны өдөрт оролцохыг урьж болно. Энэ нь улиралд нэгээс илүүгүй удаа хийгдэх ёстой. Үйл ажиллагааны өдрүүдийг бүх хүүхдүүдийг хамруулан Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөл төлөвлөнө. Энэ удирдамжийн ихэнх санаануудыг эдгээр үйл ажиллагааны өдрүүдийг төлөвлөхөд ашиглаж болно. Ерөнхийлөгчийн зөвлөл үйл ажиллагааг төлөвлөхөд болон явуулахад туслуулахаар үйл ажиллагааны өдрийн удирдагчийг болон 8–11 насны хүүхдүүдийг урьж болно.

ХҮҮХДИЙН ХЭСГИЙН УДИРДАГЧИД БОЛОН БАГШ НАР

Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн удирдлага дор Хүүхдийн Хэсгийн багш эсвэл өөр зохистой насанд хүрсэн хүн үйл ажиллагааны өдрийн удирдагчаар үйлчилдэг. Охидод зориулсан үйл ажиллагааны өдрүүдийг насанд хүрсэн эмэгтэй хүн удирдах ёстой. Үйл ажиллагааг төлөвлөхдөө удирдагчид энэ удирдамжаас “Сайн Мэдээний Миний Жишгүүд,” *Найз*-аас болон хүүхдүүдээс өөрсдөөс нь санаа авах хэрэгтэй. Эцэг эхчүүд болон онцгой ур чадвартай бусад хүмүүсийг туслуулахаар урьж болно.

Эцэг эхчүүд удирдамжуудад байгаа үйл ажиллагааг гүйцэтгэхэд, ялангуяа Хүүхдийн Хэсгийн үйл ажиллагааны өдөр цуглахад хүндрэлтэй газруудад охид хөвгүүддээ тусалж болно.

САНВААРТНЫ ХЯНАЛТ

Жил бүр бишопын зөвлөл бүх 11 настай хөвгүүд болон тэдний эцэг эхтэй санваарын ач холбогдлыг ойлгоход нь мөн үүнийг хүртэхэд бэлтгэх амлалтаа бэхжүүлэхэд нь туслахаар уулздаг. Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн бас энэ уулзалтанд оролцдог.

ТАНИЛЦУУЛГА БА БАТЛАМЖ

Охид хөвгүүдийг найман нас хүрэхэд нь Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн болон үйл ажиллагааны өдрийн удирдагч хүүхдэд болон эцэг эхэд нь удирдамжийн нэг хувийг өгөөд үйл ажиллагааны өдрүүдийн зорилго болон Бурханд Итгэх Итгэл Шагналыг хэрхэн авдгийг тайлбарладаг.

Дараах байдлаар амжилтын батламж явагдах ёстой:

1. Хүүхдүүд үйл ажиллагааг хийж дуусгаад энэ удирдамжийн 20 -р хуудсан дахь хүснэгтийг бөглөж өөрсдийн хөгжлөө тэмдэглэж болно.
2. Жилд дор хаяж хоёр удаа Хүүхдийн Хэсгийн үйл ажиллагааны өдөр тэд юу сурснаа болон гүйцэтгэсэнээ хуваалцах боломжийг хүүхдүүдэд олгох ёстой.
3. Шаардлагатай бүх үйл ажиллагааг гүйцэтгэсний дараа Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгч мөн бишоп эсвэл салбарын ерөнхийлөгч энэ удирдамжийн сүүлийн хуудас дээр байгаа Бурханд Итгэх Итгэл Шагналын гэрчилгээн дээр гарын үсэг зурдаг. Бишопын зөвлөл, салбарын ерөнхийлөгчийн зөвлөл эсвэл Хүүхдийн Хэсгийн ерөнхийлөгчийн зөвлөлийн нэг гишүүн хүүхдийн амжилтыг Хүүхдийн Хэсэг дээр зарлан танилцуулдаг.

Эцэг эх болон удирдагчид сайн мэдээний дагуу амьдрах баяр хөөр бол хамгийн чухал шагнал мөн гэдгийг ойлгоход нь хүүхдүүддээ туслах ёстой.



БУРХАНД ИТГЭХ ИТГЭЛИЙН АМЖИЛТЫН БҮРТГЭЛ

Энэ хуудсыг Бурханд Итгэх Итгэл Шагналыг авахын төлөө гаргаж байгаа өсөлтөө тэмдэглэхэд ашигла. Үйл ажиллагааг дуусгах болгонд холбогдох гарчиг доорх нэг нүдийг бөглө. Бүх болзлуудыг гүйцэтгэснийхээ дараа үйл ажиллагаануудаа болон юу сурснаа удирдагчтайгаа тоймлон хяна.

САЙН МЭДЭЭГ СУРЧ, ҮҮНИЙ ДАГУУ АМЬДРАХ НЬ

БУСДАД ҮЙЛЧЛЭХ НЬ

АВЪЯАСАА ХӨГЖҮҮЛЭХ НЬ

САНВААРТ БЭЛТГЭХ НЬ

ИТГЭЛИЙН ТУНХАГ

БИ ГЭРЧЛЭЛЭЭ БИЧСЭН

БИ БИШОП БУЮУ САЛБАРЫН ЕРӨНХИЙЛӨГЧТЭЙ
ЯРИЛЦЛАГАНД _____ ӨДӨР ОРСОН.

БУРХАНД ИТГЭХ ИТГЭЛ ШАГНАЛ

Хүүхдийн нэр

нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн Бурханд Итгэх Итгэл Шагналыг
хүлээн авах болзлуудыг хангасан болно.

Хүүхдийн Хэсгийн Ерөнхийлөгчийн гарын үсэг

Он сар өдөр

Аароны Санваарын диконы албан тушаалд
томилогдоход тэр өөрийгөө бэлтгэсэн болно.

Бишопын буюу салбарын ерөнхийлөгчийн гарын үсэг

Он сар өдөр

САЙН МЭДЭЭНИЙ МИНИЙ ЖИШГҮҮД

Би Тэнгэрлэг Эцэгийн надад зориулсан төлөвлөгөөг дагана.

Би баптисмынхаа гэрээг санаж, Ариун Сүнснийг сонсоно.

Би зөвийг сонгоно. Буруу зүйл хийсэн үедээ наманчилж болно гэдгийг би мэддэг.

Би Тэнгэрлэг Эцэгт, бусдад болон өөртөө үнэнч байна.

Би Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христийн нэрийг хүндэтгэлтэйгээр хэрэглэнэ. Би хараал хэлэхгүй, муухай үгс хэрэглэхгүй.

Би Хүндэтгэлийн өдөр Тэнгэрлэг Эцэг болон Есүс Христтэй ойртуулахад туслах зүйлсийг хийнэ.

Би эцэг эхээ хүндэтгэн, гэр бүлээ бэхжүүлэхэд өөрийн хувь нэмрээ оруулна.

Би сэтгэл санаа болон бие махбодио ариун нандин, цэвэр байлгаж, өөрт хортой зүйлсийг хүртэхгүй.

Би Тэнгэрлэг Эцэгтээ болон өөртөө хүндэтгэл үзүүлж даруухан хувцаслана.

Би зөвхөн Тэнгэрлэг Эцэгийн таашаалд нийцэх зүйлсийг уншиж, үзнэ.

Би зөвхөн Тэнгэрлэг Эцэгийн таашаалд нийцэх хөгжим сонсоно.

Би сайн найзуудыг эрэлхийлэх бөгөөд бусадтай эелдэг харьцана.

Би ариун сүмд орох, номлолд үйлчлэхийн тулд мөн мөнхийн гэр бүлтэй болоход өөрөөсөө хамаарах зүйлийг хийхийн тулд одоо зохистой амьдарна.

ЕСҮС ХРИСТИЙН

ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

MONGOLIAN



4

02368 12363

4

36812 363